

Батлав.....

УЛСЫН ШАЛГАЛТ - 2018

МОНГОЛ ХЭЛ-9

Аймаг / дүүрэг:
Сум
Сургууль:
Анги: Бүлэг:
Овог:
Нэр:

САНАМЖ, ЗӨВЛӨГӨӨ

- Шалгалт 80 минут үргэлжилнэ.
- Шалгалтын материал хоёр хэсэгтэй ба нэгдүгээр хэсэг нь унших чадвар сорьсон, хоёрдугаар хэсэг нь бичих чадвар сорьсон задгай хэлбэрийн даалгавраас бүрдэнэ.
- Даалгавар бүрийн хариултыг өгөгдсөн зайд бичиж тэмдэглэнэ.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ:

ВАНСЭМБЭРҮҮ ЦЭЦЭГ МӨХЛИЙН ИРМЭГТ ИРЭВ ҮҮ

Мөнгө л олж байвал юу ч хийхээс буцахгүй болсон иргэд минь байгаль эхээ одоо п хайрлахгүй бол цаашид ямар үр дагаварт хүрэхийг хэн ч таашгүй. Ойрын жилүүдэд олон нийтийн сүлжээгээр дэлхийд нэн ховорт тооцогдох ургамлын төрөл зүйл болох вансэмбэрүү цэцэг худалдах тухай зар түгсээр багагүй хугацаа өнгөрөөд байна. Энэ нь вансэмбэрүү цэцгийг уушгины хавдар, хатгалгаа, хүндэрсэн ханиад томууны үед хэрэглэдэг гэсэн яриа олон нийтийн дунд тархсантай холбоотой.

Сүүлийн жилүүдэд энэхүү ургамлыг худалдан борлуулах явдал ихэссэн нь нийслэл хот төдийгүй томоохон суурин газруудад агаарын бохирдол эрчимтэй нэмэгдэж, тэр чинээгээр иргэд, ялангуяа бага насын хүүхдүүдийн дунд уушги, амьсгалын замын өвчлөл нэмэгдсэнтэй хамааралтай

Вансэмбэрүү цэцэг нь манай орны Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулсаар маш ховор тархан, ихэвчлэн 3000 метрээс дээш өндөрт уулын хад асганд хосоороо 15 см-ээс нэг метр хүртэл өндөр ургадаг. Энэ ургамалд эм, эр бэлэг хамтдаа байрладаг бөгөөд өөрөөр хэлбэл, хос бэлэгтэй нэг гэрт ургамал юм. Иймээс энэ цэцгийг эрт дээр үеэс аз жаргалын бэлэг тэмдэг хэмээн нэрлэж, хосоороо ургасан вансэмбэрүүг харсан хүн аз жаргалтай амьдардаг гэж үлгэр домогт ч өгүүлэх нь бий.

Сүүлийн жилүүдэд иргэд энэхүү цэцгийг арилжааны зориулалтаар түүж бэлтгэн, өндөр үнээр худалдаалах болсноор нэн ховордож устах аюулд хүрээд байгааг ургамал судлаачид хэлж байна. Тухайлбал, Хөвсгөл аймгийн Тайгад ургадаг вансэмбэрүү цэцгийг сүүлийн хоёр жилийн хугацаанд нутгийн иргэд их хэмжээгээр түүж, бэлтгэн борлуулах болжээ. Энэ талаар нутгийн иргэнээс тодруулбал Вансэмбэрүүг уушгины өвчинд маш сайн гэж дуулаад хүмүүс их хэрэглэж, асууж сураглах болсон юм билээ. Тайгад их өндөр ууланд ургадаг. Тайгынхан очиж түүж авч ирдэг. Тэрнээс жирийн хүмүүс очоод, тэр цэцгийг таньж мэдэн, түүж чаддаггүй юм гэсэн. Тиймээс нутгийн иргэд сүүлийн үед их түүж зарах болсон. Өмнө нь хөгшчүүд тэнгэрийн цэцэг тасалбал цээртэй гэж ярьдаг байсан. Аргагүй болбол дээр нь гэр барьж аргадаж байж түүдэг гэлцэж байсан. Сүүлийн жилүүдэд тайгынхан майхантай очиж хоноод түүдэг байсан. Өнгөрсөн зунаас тайгын хэдэн айл нохой сургаж түүлгэдэг болсон. Гэрийн гөлгөн нохойг сургаад, хүний явж хүрэхгүй газраас тасдуулж авдаг. Манай нутгийнхны яриагаар нохойгоор тасдуулбал цээргүй гэх юм билээ. Тэгээд цэцгээ хатааж бэлтгээд Улаанбаатар луу хүмүүст нэг кг-ыг нь 100 мянган төгрөгөөр зардаг. Хотоос хүмүүс одоо хүртэл сурж асууж байгаа гэв.

Харин энэ тухай холбогдох албаны хүн “Улаан ном”-д орсон ургамлууд устаж байгаа шалтгаан нь 2 үндэслэлтэй. Нэгдүгээрт хүний буруутай үйлдэл, хоёрдугаарт байгалийн хүчин зүйл. Гэхдээ ихэнхдээ хүний байгальтай буруу харьцсан, байгаль эхээ хайрлахгүй байгаатай холбоотой. Адаглаад эмчилгээний зориулалтаар ашиглах гэж хулгайгаар ухаж малтаж авах нь их байна. Ялангуяа үндсийг нь ашигладаг ургамал энэ талын наймаанд их нэрвэгддэг юм. Яг ховор, ховордсон, нэн ховор ургамлуудыг гадагш нь гаргах, ашиглах, худалдаалах нь

хуулиар хориотой. Ялангуяа худалдан борлуулах тухайд. Харин судалгаа шинжилгээний зориулалтаар албан ёсны зөвшөөрлөөр, тодорхой заасан хэмжээний ургамлыг гаргадаг. Жишээ нь, буржгар сараана гэх ургамлыг жилд 5 кг-аас дээшгүй гаргана гэхчилэн зааж өгсөн байдаг. Яах вэ, өөрсдөө тарьж, ургуулаад гарган худалдаалж болох байх л даа. Байгаль дээрх, онгон зэрлэгээрээ ургамлыг дээр хэлснээр ашиглахыг хуулиар хориглосон байгаа. Нэн ховор төрлийн ургамлуудыг үрийн аргаар тариалж болох арга тал бий. Гэвч вансэмбэрүүг туршиж үзэхэд үр дүн нь муу байсан. Зарим ургамал бүр түүхэн хөгжлийнхөө явцад угаасаа мөхөж байгаа гэх юм уу даа. Мөхлийнхөө шатанд эргэлт буцалтгүй орчихсон ургамлыг яаж ч сэргээх гээд болдоггүй тийм ховор тохиолдол бий л дээ. Вансэмбэрүү ийм ургамлын тоонд ордог учир бид ургуулах гэж үзсэн ч нэг их үр дүнд хүрээгүй. Бидний ажил асар их хөрөнгө шаарддаг учир энэ мэт үр дүнгүй ургамал барьж аваад байх боломжгүй гэсэн юм.

Өнөөдөр би л мөнгө төгрөгтэй баян, тансаг амьдарч байвал бусад нь хамаагүй гэсэн үзэлтэй доройтсон сэтгэлгээтэй, хүмүүс олширч. Энэ талаар холбогдох албаны хүмүүс иргэдэд мэдлэг олгох ямар нэг үйл ажиллагаа зохион байгуулбал тэдэнд байгаль орчноо хайлрлах сэдлийг төрүүлж болох юм.

1. Ямар учраас вансэмбэрүү цэцгийг худалдах зар түгсэн бэ?

-

2. Уг ургамлыг худалдан борлуулах зах зээлд нөлөөлсөн шалтгаан юу вэ?

-

3. Вансэмбэрүүг харсан хүн аз жаргалтай амьдардаг гэх болсны учир юу вэ?

-

-

4. Эхэд байгаа дараах үгсийн утгыг тайлбарлаарай.

Домог-.....

Цээр-

Зэрлэг -

5. Вансэмбэрүү цэцгийг ямар аргаар түүж авдаг вэ?

-

-

-

-

6. Эхээс улаан номд орсон ургамлууд устаж байгаа шалтгааныг хүний буруу үйлдэл, байгалийн хүчин зүйл гэж ангилсныг ялган, өөрийн үгээр 50-60 үгэнд дүгнэж бичээрэй.

Хүний буруу үйлдэл:

Байгалийн хүчин зүйл:

7. Үндэсний бичгээс кирил бичигт хөрвүүлээрэй.

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

ХОЁРДУГААР ХЭСЭГ:

Дээрх “Вансэмбэрүү” эхэд мөхөж устаж үгүй болж буй ховор ургамлын талаар баримт мэдээлэлтэй өгүүлжээ.

“Вансэмбэрүү” эхийн найруулгын арга хэлбэрийг ашиглан “**Сарнай**” сэдвээр 180-200 угэнд багтаан эх зохион бичээрэй.

Бичихдээ дараах агуулгын бүтцийг ашиглаж болох юм.

- **Эхлэл хэсэг :** - сарнай цэцгийг хараад ямар мэдрэмж төрдөг тухайгаа дүрсэлж бичих
- **Гол хэсэг :** - сарнай цэцгийн бэлгэдэл, ач холбогдлын талаар үзэл бодлоо дэлгэрүүлж бичих, мөн холбогдох түүх, яриагаар баяжуулах
- **Төгсгөл хэсэг :** - уг цэцэгтэй холбоотой дурсамжийг бичиж төгсгөх.

